

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2022 оны 12 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.

Улаанбаатар хотын 2022 оны хүйтний улирал 12 дугаар сарын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 9 мкг/м³-ээр буюу 8 %-иар, PM10 тоосонцор 32 мкг/м³-ээр буюу 19 %-иар, азотын давхар исэл (NO₂) нь 3 мкг/м³-ээр буюу 4 %-иар тус тус бага, харин хүхэрлэг хий (SO₂) нь 4 мкг/м³-ээр буюу 3 %-иар их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2021 оны 12 дугаар сар	2022 оны 12 дугаар сар
PM2.5 тоосонцор	50	112	103
PM10 тоосонцор	100	164	132
Азотын давхар исэл, NO ₂	50	71	68
Хүхэрлэг хий, SO ₂	50	142	146

Улаанбаатар хотын сүүлийн 6 жил буюу 2017-2022 оны 12 дугаар сарын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт дэлгэрэнгүй үзүүлж байна.


PM2.5 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцор 2022 оны 12 дугаар сарын дундаж агууламж 103 мкг/м³ байна. 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 8%-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 2 дахин их байна. (Зураг 1).


PM10 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2022 оны 12 дугаар сарын дундаж агууламж 132 мкг/м³ байна. 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 19 %-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.3 дахин их байна. (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Азотын давхар ислийн 2022 оны 12 дугаар сарын дундаж агууламж 68 мкг/м³ байна. 2021 оны мөн үетэй харьцуулахад 4%-иар бага. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.3 дахин их байна. (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2022 оны 12 дугаар сарын дундаж агууламж 146 мкг/м³ байна. 2021 оны мөн үетэй харьцуулахад 3%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 2.9 дахин их байна. (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС